

6. Үнэт цаасыг арилжаалахад зуучлах мэргэжлийн байгууллагын тухай мэдээлэл:

Компани анх 1991 онд Төв аймгийн иргэдийн өмч хувьчлалын тасалбарыг бүртгэх, бичилт хийх зорилгоор Баяндөхөм брокерын нүүс нэртэйгээр анх байгуулагдсан. 1995 онд Хөрөнгийн зах зээлд брокер дилерийн иж бүрэн үйл ажиллагаа явуулахаар “БиДиСЕК” ХХК болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

- *1997 онд Улаанбаатар хотод анх салбараа нээж, 1998 онд компанийн төвийг Улаанбаатар хотод шилжүүлсэн.*
- *МХБ-ийн шалгуур үзүүлэлтээр 2002, 2004,2005 онуудад тэргүүний үнэт цаасны компани, 2003 онд дэд байрын шагналт үнэт цаасны компаниар шалгарсан.*

“БиДиСЕК” ХК-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь

- *Брокер Дилерийн үйл ажиллагаа*
- *Андеррайтерын үйл ажиллагаа*
- *Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа*

“БиДиСЕК” ХХК нь 2006 онд компанийн зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн “БиДиСЕК” ХК болж хувьцаагаа олон нийтэд санал болгон арилжаалсан.

“БиДиСЕК” ХК нь 2005 оноос хойш дараах үнэт цаасны андеррайтераар ажилласан байна.

Хувьцаа:


- *Женко Тур Бюро ХК*
- *Монинжбар ХК*
- *Хай Би Ойл ХК*
- *Туул Сонгино усны нөөц ХК*
- *БиДиСЕК ХК*

Бонд:


- *Монинжбар ХК-ийн Бүтээн байгуулалт бонд*
- *Пума ХХК-ийн Пума бонд*
- *Нийслэл өргөө ХК-ийн Нийслэл өргөө бонд*

БиДиСЕК ХК 2007 онд МХБ-ийн нийт арилжааны 52,5%-ийг дангаар хийж гүйцэтгэсэн байна. 2000 оноос хойш арилжаанд оролцсон байдлыг графикаар харуулав.

Хувьцааны арилжаа




Компанийн бондын арилжаа



Мянган төгрөгөөр

Засгийн газрын бондын арилжаа



сая төгрөгөөр